



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 41164

Улаанбаатар хот

Г Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2016 онд төсвийн хөрөнгөөр оруулалтаар хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын XVII.1.3.19 Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж төсөл арга хэмжээний хүрээнд Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 63 дугаар тоот тушаалаар батлагдсан /Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн дижитал эхо аппарат/ ажлын 129,800,000.0 /нэг зуун хорин есөн сая найман зуун мянган/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, санхүүжүүлэх/-ийг Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга /А.Чулуунцэцэг/-д шилжүүлсүгэй.
2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн дарга /А.Чулуунцэцэг/-д даалгасугай.
3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ОЮУНБААТАР



080574